



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/563

Мөрөн сум

Иргэний газар өмчлөх эрхийг цуцлах,
газрын хэмжээнд өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7.1, 12.1.3, 21.1, 31.1.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, 40.2.4, 40.2.5, 94 дүгээр зүйлийн 94.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар өмчилсөн нэр бүхий 7 иргэний өөрсдийнх нь хүсэлтийн дагуу газар өмчлөх эрхийг цуцалж, кадастрын зургаар талбайн хэмжээнд өөрчлөлт орсон 7 иргэний 5645м² газрын хэмжээг хавсралт ёсоор баталж өмчлүүлсүгэй.

2. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусган захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д, эрхийн баталгаанд өөрчлөлт хийхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Эрдэнэбилэг)-т тус тус даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

01111099